



I/2022

Тархаасан: 2022 оны 3 дугаар сарын 14




## Нийтийн хоолны салбарын орлого өмнөх оны мөн үеэс 95.5 хувиар өсжээ

Нийтийн хоолны салбарын орлого 2022 оны 1 дүгээр сард 60.6 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 29.6 тэрбум төгрөг буюу 95.5 хувиар өсжээ. Үүнд рестораны орлого өмнөх оны мөн үеэс 23.8 (2.7 дахин) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Нийтийн хоолны салбарын орлого 2021 оны 12 дугаар сард 92.0 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 16.4 (21.6%) тэрбум төгрөгөөр өсөж байсан бол, 2022 оны 1 дүгээр сард 60.6 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 31.4 (34.1%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

ЗУРАГ 1. НИЙТИЙН ХООЛНЫ САЛБАРЫН ОРЛОГО, төрлөөр, тэрбум төгрөг, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар



Рестораны орлогын эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 17.1 нэгж хувь, баарных 1.8 нэгж хувиар өсөж, харин захиалгат хоолны хүргэлтийн үйлчилгээний орлогын эзлэх хувь 14.8 нэгж хувь, гуанзных 4.1 нэгж хувь, кафеных 0.1 нэгж хувиар тус тус буурсан байна.


## Зочид буудлын салбарын орлого өмнөх оны мөн үеэс 2.2 дахин өсжээ

Зочид буудлын салбарын орлого 2022 оны 1 дүгээр сард 23.4 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 12.7 тэрбум төгрөг буюу 2.2 дахин өсжээ. Үүнд 3 ба түүнээс дээш одтой буудлын орлого 9.7 (2.4 дахин) тэрбум төгрөг, зэрэглэлгүй зочид буудал болон амралтын газрын орлого 2.6 (76.8%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Зочид буудлын салбарын орлого 2021 оны 12 дугаар сард 48.6 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 21.2 (77.6%) сая төгрөгөөр өсөж байсан бол, 2022 оны 1 дүгээр сард 23.4 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 25.2 (51.8%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Үүнд 3 ба түүнээс дээш одтой буудлын орлого 13.0 (43.6%) тэрбум төгрөг, зэрэглэлгүй зочид буудлын орлого 11.9 (66.4%) тэрбум төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Зочид буудлын салбарын 2022 оны 1 дүгээр сарын орлогод 71.8 хувийг 3 ба түүнээс дээш одтой зочид буудал, 25.8 хувийг зэрэглэлгүй зочид буудал, амралтын газар, 2.4 хувийг 2 одтой зочид буудлын орлого эзэлж байна.

ЗУРАГ 2. ЗОЧИД БУУДЛЫН САЛБАРЫН ОРЛОГО, зэрэглэлээр, тэрбум төгрөг, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар



**Ойлголт, тодорхойлолт:**

Нийтийн хоолны салбарт ресторан, кафе, баар, гуанз, захиалгат хоол хүргэх, үйлчлэх үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжүүдийг хамруулна.

Зочид буудлын үйл ажиллагаанд зочид буудал, амралтын газар, хүүхдийн зуслан, түр хоноглох байруудын үйл ажиллагаа хамрагдана.



**Эх үүсвэр:**

Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч хуулийн этгээдийн мэдээллийн сан

**Ангилал, код:**

Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал

**Мэдээлэл авах холбоос:**

<http://www.nso.mn/>  
<http://www.1212.mn/>

**Дараагийн мэдээ гаргах хуваарь:**

2022 оны 5 дугаар сарын 12

Эдийн засгийн статистикийн газрын  
дарга А.Дэмбэрэл  
Утас : (976-51)-329278

Эдийн засгийн статистикийн газрын  
статистикч Ч.Мөнхтуул  
Утас : (976-51)-264797



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212